




ХАСБАНК

БОНЗ-ын үйл ажиллагааны тайлан

2023 он

ХАСБАНК ХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Огноо (он, сар, өдөр):	2024.03.26
Үнэт цаас гаргагчийн нэр:	ХасБанк ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	ХАС MN00ХАС05687
Салбарын ангилал:	Банк санхүү
Тайлангийн хамрах хугацаа:	2023.01.01 - 2023.12.31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга munkhtselmeg.n@хасбанк.mn
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Г.Цэвэгжав, Гүйцэтгэх захирал
Гүйцэтгэх захирлын гарын үсэг:	

	Бүлэг	Шалгуур үзүүлэлт		Үзүүлэлт (өмнөх он)	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд									
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/ мэдэгдэл байдаг эсэх		Тийм		Тогтвортой хөгжлийн асуудал, Нийгэм байгаль орчинд ээлтэй байх, Нийгэм байгаль орчны эрсдэлийг удирдах, хариуцлагатай банкны үйлчилгээ гэх мэт ойлголт нь ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд анхлан тусгагдаж, банк уг чиг үүргийг банкны бүх үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Хувьцаа эзэмшигчдийн гэрээ (Shareholder's agreement)-д тусгагдсан үүрэг амлалт тул Банкны эрхэм зорилгод мөн тодорхойлогдсон. https://xacbank.mn/page/about		GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх		Тийм				GRI 103, ISO 14001
MS2.2		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх		Тийм		Тогтвортой Хөгжлийн Хороо: Хорооны дарга: Гүйцэтгэх захирал, Гишүүд: Эрсдэл хариуцсан захирал, Иргэдийн банкны газрын захирал, Үйл ажиллагааны газрын захирал, Эко банкны газрын захирал, Эрсдэлийн бодлого хяналтын хэлтсийн захирал, Лизингийн газрын захирал.		GRI 103, ISO 14001
MS3.1			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх		Тийм		Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороо нь тогтвортой хөгжлийн стратеги, болон нийгэм байгаль орчны эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хянаж, Банкны ТУЗ-д тогтвортой хөгжлийн стратегийг хэлэлцэж батлахад дэмжлэг үзүүлдэг. Иймд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хорооны гишүүд нь уг асуудлыг хариуцан ажиллана.		GRI 102
MS3.2			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх		Тийм		Эрсдэл хариуцсан захирал нь нийгэм, байгаль орчны эрсдэлийн удирдлагыг хариуцдаг буюу тус чиглэлийг үйл ажиллагааны үндсэн зорилт, чиг үүрэгтээ багтаасан нэгжийг удирдлагаар ханган ажилладаг. Түүнчлэн ХасБанкны Гүйцэтгэх Захирал нь банкны тогтвортой хөгжлийн хороо даргалан ажилладаг тус банкны тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцан ажиллаж байна.		GRI 102
MS3.3		Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх		Тийм		Эрсдэлийн бодлого, хяналтын хэлтэст Ахлах мэргэжилтэн, Мэргэжилтэн гэсэн албан тушаалтнууд байдаг. Тус хэлтсийн БОНЗ-той холбоотой үйл ажиллагааны үндсэн зорилт, чиг үүрэг: Нийгэм байгаль орчны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, сайн туршлагыг бий болгох, хэрэгжүүлэх, бодлого; Нийгэм, байгаль орчны эрсдэлийн удирдлагатай холбоотой тайлан мэдээ бэлтгэх; Нийгэм, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг хөгжүүлэх, мэдээллийн бааз бий болгох; Нийгэм, байгаль орчны эрсдэлийн удирдлагыг бууруулах арга хэмжээ авах чиглэлийг тодорхойлох; мөн Нийгэм, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн талаар газар, хэлтэс, салбар, тооцооны төвийн холбогдох ажилтнуудыг сургалт мэдээллээр хангах, уур амьсгалын эрсдэлтэй холбоотой асуудлаар банкныг төлөөлөх юм.		GRI 102	
MS3.4	Бүтэц удирдлага	Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?		Тийм		Тогтвортой хөгжил болон нийгэм байгаль орчны эрсдэлийн удирдлагын асуудал нь ХасБанкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хорооны хэлэлцэх асуудалд багтдаг. Улмаар Эрсдэлийн Удирдлагын Хорооны өргөн мэдүүлснээр ТУЗ хэлэлцэх асуудлын хүрээнд багтааж хэлэлцдэг.		GRI 102	

MS3.5	Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх		Тийм		ХасБанк нь өөрийн үйл ажиллагааны бүх процесст процессын үнэлгээ хийдэг.		SASB
MS4.1	Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр		1.30	Цаг	Тогтвортой хөгжлийн хүрээнд давхардсан тоогоор 1151 ажилтан, нийтдээ 1,459 цагийн сургалтад хамрагдсан байна.		GRI 102
MS4.2	Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?		Тийм		ХасБанкны Аудитын хороо нь ТУЗ-өөс баталсан дүрмийн хүрээнд хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгчид болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд ТУЗ-д дэмжлэг үзүүлнэ. Үүнд: 1. Банк нь хууль болон эрх зүйн зохицуулалтын шаардлага нийцэл; 2. Хөндлөнгийн аудиторын ур чадвар, хараат бус байдал; 3. Банкны дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэл; 4. Дотоод болон хөндлөнгийн аудитын тайлан, удирдлагын захидлыг хүлээн авч шаардлагатай бол аудитортай уулзаж, аудиторын зөвлөмжид хариу өгөх 5. Банкны дотоод хяналтын тогтолцоо. Эдгээр чиг үүргийн хүрээнд тогтвортой байдлын асуудал Аудитын хороо болон дотоод аудитын нэгжийн хамрах хүрээнд хамаарагдана. Мөн Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн баталсан Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогод Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын 3 бүсийн зарчимд суурилна гэж тодорхойлсон байдаг. Аудит нь хамгаалалтын 3-р бүсийн хувьд Хамгаалалтын 1-р бүс болох бизнес нэгж болон хамгаалалтын 2-р бүс болох эрсдэлийн функцуудын хяналтын тогтолцоо болон түүний үр дүнтэй байдал зэрэгт хөндлөнгийн аудит хийдэг үүрэгтэй.		GRI 102, SDG 12
MS4.3	Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жилд нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?		Тийм		Тогтвортой байдал/хөгжлийн асуудал нь ХасБанкны жилийн тайланд тусгагдсан байдаг. 2024 оноос эхлэн бид анхны Тогтвортой хөгжлийн тайлангаа тусад нь бэлтгэж тайлагнадаг болохоор ажиллаж байна. Уг тайланд уур амьсгалын эрсдэл болон Score 1,2 зэргийг тайлагнана. Үүнээс гадна эх үүсвэр олгогч байгууллагуудад болон Хувьцаа эзэмшигчдэд тэдний ирүүлсэн маягтын дагуу тогтвортой хөгжил, тогтвортой байдлын тайланг жил бүр тусгайлан бэлтгэж хүргэдэг.		GRI 102, SDG 12
MS5.1		Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?		Тийм		Тогтвортой хөгжлийн тайланг бид TCFD, SASB болон GRI стандарт нийцүүлэн тайлагнахаар бэлтгэж байна.		GRI 102, SDG 12

MS5.2		Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?		Тийм		ХасБанк нь анх 2010 болон 2014 онуудад Planet Rating байгууллагаар өөрийн засаглал болон нийгмийн хариуцлагын үнэлгээгээ үнэлүүлж байсан. ХасБанкны хөрөнгө оруулагчид болон эх үүсвэр олгогч хамтран ажиллагч байгууллагуудаас ХасБанкны Тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн шалгалтыг тогтмол хийдэг. Жишээ дурдвал ХасБанк нь 2016 болон 2022 онуудад Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур Амьсгалын Ногоон Сан ("GCF") байгууллагаар 2 удаа магадлан итгэмжлэгдсэн Монгол улсын анхны банк бөгөөд тус байгууллагаас ХасБанкны тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт хийж баталгаажуулсны үндсэн дээр магадлан итгэмжилсэн. Түүнээс гадна гадны хөрөнгө оруулагч байгууллагуудаас ХасБанкны үйл ажиллагаанд тогтмол хяналт судалгаа хийгддэг бөгөөд хамгийн сүүлд GCF байгууллагаас 2023 оны 12 сард ХасБанкны ногоон болон эко зээлийн санхүүжилтийн үйл ажиллагаанд аудит хийсэн.		GRI 102, SDG 17
MS5.3	Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?		Тийм		Global Alliance for Banking on Values, The United Nations Global Compact, Partnership for Carbon Accounting Financials, Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо.		GRI 102, SDG 17
Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд								
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	3,111	Мега Втц '000	ХасБанкны төв оффис болон нийт салбар нэгжийн нийт цахилгааны зарцуулалт		GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	2,380	Мега Втц '000	а. 2021-2023 оны хугацаанд их засварт орсон бүх салбар, төв албаны объектуудын цахилгааны монтажийг дахин шинээр суурилуулснаар эрчим хүчний шугамын алдагдлыг бууруулсан б. Сэргээгдэх эрчим хүчийг ашиглахаар 19.6кВт-ын нарны панел суурилуулж төв байрны эрчим хүчийг 15% хэмнэх боломжийг бүрдүүлсэн в. Сэлэнгэ, Багануур салбаруудын байранд тус бүрд 9.8кВт-ын нарны панелууд суурилуулж салбарын эрчим хүчний хэрэглээг 40 хүртэл хувь хэмнэх боломжийг олгохоор гэрээг байгуулан ажиллаж байна.		GRI 302, SDG 12
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	2,494,373,775.6	BTU	а. Цогтцэций салбарын байрыг цахилгаанаар халдаг байсныг төвийн халаалтад холбосноор дулааны зардлыг 60% бууруулсан; мөн б. Төв байрны дулааны системд эргэлтийн насос суурилуулан халаалтын усыг дахин эргэлтэд оруулснаар төв байрны дулааны зардлыг 30% бууруулсан.		GRI 302, SDG 12
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	179,610.11	Литр	а. Дизель автомашины тоог бууруулан зөвхөн бензин хөдөлгүүртэй автомашин ашигладаг байх бодлогыг баримталдаг болсон; б. Төв албаны үйлчилгээнд 5 ширхэг цахилгаан автомашин ашигладаг болсноор түлшний зардлыг бууруулаад зогсохгүй, дугаарын хязгаарлалтад өртөхгүйгээр 100%-ийн хэрэглээнд шилжүүлсэн; мөн в. Дата төв болон Төв байрны нэмэлт цахилгаан үүсгүүрийн түлшний зардалд хяналтыг сайжруулснаар өмнө нь гарч байсан өвөл зуны түлшээр солих жилийн 120 сая орчим төгрөгийн зардлыг бууруулсан.		GRI 302, SDG 12
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-нээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100	%	Төвийн эрчим хүч		SFRD

E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0	%		ХасБанкны төв байр болон салбар нэгжүүдэд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд байршуулсан. Нэмэлт тохиргоо хийсний дараа ашиглаж эхлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.	GRI 302, SDG 7
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	2,932	CO2/тонн	Нийт хэмжээ (L эсвэл kWh) *Emissions factor (kgCO2/L эсвэл tCO2/MWh) https://cdm.unfccc.int/sunsetcms/storage/contents/stored-file-20180718120947843/ASB0039-2018_PSB0041.pdf		GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)		CO2/тонн		Одоогоор хэмжих боломжгүй байна	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ / Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт) бууралт	2,442,800	CO2/тонн	ХасБанк нь 2013 оноос хойш өөрсдийн төсөл хөтөлбөрүүдээрээ дамжуулан нийтдээ 2.4 сая тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан. Энэ нь 175,992,135 ширхэг шилмүүст буюу навчит мод тарьж ургуулсантай тэнцэх бөгөөд энэ нь Улаанбаатар хотоос 1.25 дахин том газрыг бүрхэх хэмжээтэй юм.		GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм		ХасБанк нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх санхүүгийн эрсдэлийг ХасБанкны Эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо тусгасан. Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн удирдлагын талаар тусгайлан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд 2023 онд шилжилтийн төлөвлөгөөгөө ХасБанкны ТУЗ-аар батлуулсан.		GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй			Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн удирдлагын талаар тусгайлан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд 2023 онд шилжилтийн төлөвлөгөөгөө ХасБанкны ТУЗ-аар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу 2024 онд сценарийн шинжилгээ хийгдэнэ.	GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	0	Төгрөг	2023 онд болсон томоохон уур амьсгалын өөрчлөлтүүдэд ХасБанкны барьцаа хөрөнгө өртөөгүй болно.		GRI 201, TCFD, SDG 13
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн		Төгрөг	ХасБанк нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, эрчим хүчний хэмнэлт үүсгэх, хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр ногоон эко банкны бүтээгдэхүүнээр харилцагчдад үйлчилж хөрөнгө оруулж санхүүжүүлж байна. Эдгээр бүтээгдэхүүн үйлчилгээ болон багцын мэдээллийг МонголБанкинд сар бүр тайлагнан ажилладаг.		GRI 201, TCFD, SDG 13

E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/ алхмуудыг тодорхойлсон уу?		Үгүй			Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн удирдлагын талаар тусгайлан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд 2023 онд Шилжилтийн төлөвлөгөөгөө ХасБанкны ТУЗ-аар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу 2024 онд уг ажил хийгдэнэ.	GRI, SASB, World Economic Forum
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ		76,608,744	м3/Л			GRI 303, SDG 6
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/ дахин боловсруулсан усны хэмжээ			м3/Л	а. Төв байр болон засварт орсон салбаруудын угаалтуур, суултуурыг усны хэмнэлттэй тоноглолуудаар сольж усыг хэмнэсэн; мөн б. Төв байранд төвийн шугамаас зөвхөн хүйтэн ус хүлээн авч, дотоодын хүчин чадал сайтай бойлер суурилуулснаар байнга халуун устай болохоос гадна, төвийн шугамаас авах халуун усны хэрэглээг зогсоосон.	GRI 303, SDG 6	
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь			%		Ус дахин боловсруулах систем байхгүй.	GRI 303, SDG 6
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ			м3/Л		Оффисын үйл ажиллагаа эрхэлдэг тул хаягдал бохир ус цэвэрлэх систем байхгүй.	GRI 303, SDG 6
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	27.4	тонн	Банкны хэмжээнд хог хаягдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс дурдвал: Оффисын үйл ажиллагаанд цаасгүй технологид шилжиж paper management хийн принтерийг бүрэн хяналттай болгосон. Түүнчлэн маркетингийн хэвлэмэл маягтыг хэрэглэхээ больсон.		GRI 306, SDG 12	
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	62.99%	%	17.28 тонн төмрийн хаягдлыг шинэчлэн архивын баримт хадгалах тавиур болгож дахин ашигласан.		GRI 306, SDG 12	
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	0	тонн		Хортой хог хаягдал гардаггүй.	GRI 306, SDG 12	
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь		%	Хас Төгөл хөтөлбөр нь – 21 аймагт 2009 оноос эхэлсэн Зорилго: Байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангах, цөлжилттэй тэмцэх Нийт 40 мянга орчим мод тарьсан ба байнгын арчилгаа тордлогоо хийж ургалтын хувь 87%-тай байна. 2023 оны хувьд ХасБанкны ажиллагсдын үүсгэн байгуулсан Хас Төрийн бус байгууллагаараа дамжуулан "Эзэнтэй Мод" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт 12 байршилд 521 мод тарьсан байна.		GRI 304, SDG 15	
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо		Төрөл зүйлийн тоо	Тосонхулстайн байгаль хамгаалах төсөл – ХасБанк болон Nature Conservancy ОУБ Зорилго: Тосонхулстайн байгалийн нөөц газар болон цагаан зээрийг хамгаалах		GRI 304, SDG 15	

E6.3	Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэн өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь			%	Тосонхулстай байгалийн нөөц газрыг хамгаалах, энэхүү ажлыг зохион байгуулснаар нутгийн иргэд болон малчдын тогтвортой амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх, энэ бүс нутгаа нутгийн иргэд өөрсдөө хайрлан хамгаалах санал санаачилгыг хөхүүлэн дэмжих, мөн сүүлийн жилүүдэд тоо толгой нь эрс багасаж, мөхлийн аюул нүүрлээд байгаа цагаан зээрийг хамгаалах, хил даван дайжихаас сэргийлэх, хулгайн анчидтай тэмцэх ажлуудад хувь нэмрээ оруулсан.	SFRD, IFC Performance Standard 6	
Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд								
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)		19.6	%	2023 онд Хүний нөөцийн тогтвортой байдлын хувь 19.6% байсан.	GRI 401, SDG 8
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо		286	Тоо	2023 онд 286 шинэ ажилтныг бүтэн цагийн ажлын байранд ажилд авч, хөдөлмөрийн гэрээ байгуулсан.	GRI 401, SDG 8
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг		17,58	Цаг	Цахим сургалтын хувьд нийт 332 цагийг зарцуулсан бүх төрлийн сургалт байдаг. Танхимын сургалтын хувьд нэг ажилтанд 39 минут дунджаар ноогдож байна.	GRI 401, SDG 8
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?			Тийм	ХАБЭА-н бодлого, журам тусдаа байхгүй боловч Хөдөлмөрийн дотоод журамд зарим холбогдох заалтуудыг тусгасан байдаг. (Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5 дахь заалт) ДОЛДУГААР ЗҮЙЛ. АЖИЛТНЫГ ШИЛЖҮҮЛЭН БОЛОН СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ 7.2.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажил, албан тушаалд хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл хугацаагаар ажиллуулах шаардлагатай болсон; НАЙМДУГААР ЗҮЙЛ. БАНК БОЛОН АЖИЛТНЫ ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ 8.1. Банк нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд: 8.1.1. Албан тушаалын онцлогт тохирсон эрүүл ахуйн болон аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангасан ажлын байр, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж материалаар ажилтныг хангах; 8.1.3. Ажилтныг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, шимтгэл хураамжийг сар бүр төлөх; 8.1.5. Гүйцэтгэх Захирлын тушаалаар ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах хүнсний зүйлийг хэрэглэх шаардлагатай ажилтнуудад баталсан хэмжээгээр өгөх; мөн 8.1.6. Ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа холбогдох хууль тогтоомжид заасан шалтгаанаар эрүүл мэндээрээ хохирсон бол түүнд тэтгэмж олгох.	GRI 103, SDG 10
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь			%	2023 онд нийт 3 үйлдвэрлэлийн осол гарсан. Цаг үеийн эрсдэлтэй нөхцөл байдлыг анхааруулсан мэдээ мэдээлэл, постерийг дотоод сүлжээгээрээ дамжуулан ажилтнуудад тухай бүрд нь мэдээлэл хүргэдэг. Ажилтнуудаа жил бүр гэнэтийн ослын даатгалд хамруулдаг.	GRI 403, SDG 3

S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	90	Минут	Ажлын байран дахь ХАБЭА анхан шатны зааварчилгаа өгдөг.		GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилтны тоо, жилээр	1001	Хүн	2023 онд нийт 1001 ажилтан Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан.		GRI 403, SDG 3
S3.1	Эрх тэгш байдал	Жендэрийн бодлого, журам	Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй		Жендэрийн журам одоогоор байхгүй ба 2024 онд батлуулахаар ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан холбогдох заалтууд: НАЙМДУГААР ЗҮЙЛ. БАНК БОЛОН АЖИЛТНЫ ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ 8.5. Ажилтан нь дараах ёс зүйг чанд баримтлан ажиллана. Үүнд: 8.5.2. Харилцагчийн эрх ашгийг хүндэтгэж, яс үндэс, хүйс, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, хөгжлийн бэрхшээлтэй болон гадаад байдал, танил тал зэргийг харгалзан ялгаварлан харьцахгүй байх; Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны журамд доорх заалтыг тусгасан байдаг. 3.1. Нийтэд нээлттэй, ил тод, шударгаар хүний нөөцийг бүрдүүлж, эрх тэгш, сайн дурын харилцаанд үндэслэн үндэс угсаа, нас хүйс, хэл, арьсны өнгө, хөрөнгө чинээ, нийгмийн гарал, гэрлэлтийн байдал, шашин шүтлэгээр үл ялгаварлан гадуурхах зарчмаар, тэгш эрхийн үндсэн дээр сонгон шалгаруулна.		GRI 405, SDG 5
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм		Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам тусдаа байхгүй боловч Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байдаг. (Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.5.15, 8.5.16, 8.5.19 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.15.1.20 дахь заалт) ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ НАЙМДУГААР ЗҮЙЛ. БАНК БОЛОН АЖИЛТНЫ ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ 8.5. Ажилтан нь дараах ёс зүйг чанд баримтлан ажиллана. Үүнд: 8.5.15. Удирдах ажилтан нь ажилтантай хувийн дотно харилцаа тогтоосон эсхүл тогтоох зорилгоор ажилтныг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх, эрхэлж буй албан тушаалд нь хэвээр үлдээх болон бусад байдлаар түүнд давуутай байдал бий болгох, дээрх боллоор далимдуулан ажилтныг бэлгийн харьцаанд орохыг шаардахгүй байх. 8.5.16. Ажилтан нь бусад ажилтныг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлэх, хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулах, бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэргээр		GRI 103, SDG 5

					<p>ажилтанд аливаа хэлбэрээр бэлгийн дарамт үзүүлэхгүй байх</p> <p>8.5.19. Харилцагч эсхүл ажилтанд бэлгийн болон сэтгэлзүйн дарамт үзүүлэхгүй, харилцагчийн эрхэнд халдсан аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх.</p> <p>АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. АЖИЛТАНД НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭ АВАХ, САХИЛГЫН ШИЙТГЭЛ НОГДУУЛАХ</p> <p>14.15.1. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг шууд цуцлах ноцтой зөрчлүүдэд дараах зөрчлүүдийг тооцно. Үүнд:</p> <p>14.15.1.20. Ажилтан нь бусад ажилтныг хүсээгүй байхад бэлгийн сэдлээ уг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, бэлгийн харилцаанд орохоос аргагүй байдалд оруулсан, бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэсэн, хөдөлмөрийн нөхцөлд ил болон далд хэлбэрээр нөлөөлөх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэргээр ажилтанд аливаа хэлбэрээр бэлгийн дарамт үзүүлсэн, ажилтан уг үйлдлийг хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран түүнийг хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор аливаа шийдвэр гаргах үндэслэл болсон, уг үйлдэл нь ажилтны ажлын гүйцэтгэлд нөлөөлсөн;</p>	
S3.3	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэгсэн)?	Тийм	<p>Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байдаг. (ХДЖ-ын 8 дугаар зүйлийн 8.5.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт)</p> <p>ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ НАЙМДУГААР ЗҮЙЛ. БАНК БОЛОН АЖИЛТНЫ ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ</p> <p>8.5. Ажилтан нь дараах ёс зүйг чанд баримтлан ажиллана. Үүнд:</p> <p>8.5.2. Харилцагчийн эрх ашгийг хүндэтгэж, яс үндэс, хүйс, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, хөгжлийн бэрхшээлтэй болон гадаад байдал, танил тал зэргийг харгалзан ялгаварлан харьцахгүй байх;</p> <p>АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. ЗӨРЧЛИЙГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ</p> <p>15.1. Зөрчлийг шалган шийдвэрлэхэд дараах нийтлэг зарчмуудыг баримтлан ажиллана.</p> <p>15.1.4. Ажилтны үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, албан тушаал, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэнд, боловсролын байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхийг нь үл харгалзан, ялгаварлалгүй хандан холбогдох арга хэмжээг авах – эрх тэгш;</p> <p>ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ</p> <p>Хүний нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:</p> <p>3.1 Нийтэл нээлттэй, ил тод, шударгаар хүний нөөцийг бүрдүүлж, эрх тэгш, сайн дурын харилцаанд үндэслэн үндэс угсаа, нас хүйс, хэл, арьсны өнгө, хөрөнгө чинээ, нийгмийн гарал, гэрлэлтийн байдал, шашин шүтлэгээр үл ялгаварлан гадуурхах зарчмаар, тэгш эрхийн үндсэн дээр сонгон шалгаруулна.</p>	GRI 103, SDG 10	
S3.4	Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	37%:63%	%	Нийт ажилтнуудын 37% буюу 431 эрэгтэй ажилтан, 63% буюу 741 эмэгтэй ажилтан байна.	GRI 405, SDG 5
S3.5	Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	73%:27%	%	Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 73% буюу 7 эрэгтэй, 27% буюу 3 эмэгтэй гишүүдтэй байна.	GRI 405, SDG 5

S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	64%:36%	%	Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн 64% буюу 7эрэгтэй, 36% буюу 4эмэгтэй гишүүд байна.		GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	48%:52%	%	Дунд шатны удирдах ажилтнуудын 48% буюу 58 эрэгтэй, 52% буюу 66 эмэгтэй удирдах ажилтнууд байна.		GRI 405, SDG 5
S3.8		Жендэрт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	9%	Харьцаа	Эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн зөрүү 9% байна.		GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм		Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байдаг. (ХДЖ-ын 11 дүгээр зүйлийн 11.20 дахь заалт) ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. АЖИЛТАНД ОЛГОХ ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛАЛ, ТЭТГЭМЖ, НӨХӨН ОЛГОВОР 11.20. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх толгойлсон эх буюу ганц бие эцэг бөгөөд өрхийн орлого нь тухайн бүсийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур байгаа ажилтанд түүний хүсэлтийг үндэслэн тухайн жилд нэг удаа тэтгэмж олгож болно.		SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	0.014	%	Банкны хэмжээнд нийт 16 хөгжлийн бэрхшээлтэй ажилтан байдаг.		SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Тийм		ХасБанкны төв байр болон дата төвийн барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарцтай.		SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	Үгүй	Төгрөг		2023 онд зөрчил, торгууль байхгүй.	SDG 10

S5.1	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?		Тийм	<p>ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан, ёс зүйд тулгуурласан зан суртахууны соёлыг төлөвшүүлэх зорилгоор баталсан “ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-аар банкны оролцогч талуудтай харилцах харилцаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон. Мөн ХасБанкны толгой компани болох Тэнгэр санхүүгийн нэгдэл ХХК-иас баталсан, тус нэгдэл дэх охин компаниудын хэмжээнд дагаж мөрддөг засаглалын кодексийг ХасБанкны түвшинд буулган “ХасБанкны Засаглалын кодекс”-ийг шинээр баталсан. Уг баримт бичиг нь урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжлийн чухал бүрэлдэхүүн болох компанийн засаглалыг сайжруулах зорилготой. Түүний 1-р хэсгийн 1-д банк нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй байх зарчмуудыг баримтлах, 3-р хэсгийн 2-т “санал хураалтад жижиг хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрхийг онцгойлон харгалзаж үзэх, Монголбанкны журмын дагуу ТУЗ-д хэд хэдэн хараат бус гишүүнийг томилох, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдээллийг тухай бүр авах эрхээ саадгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг чухалчилна. Бүх хувьцаа эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай буюу хангалттай мэдээллээр хангана” гэж оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах талаар зохицуулалтыг тусгасан.</p> <p>Түүнчлэн, ХасБанк нь хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар болон цахим шуудангаар харилцах харилцааг үнэн зөв, ижил жигд, хууль тогтоомжид нийцсэн байдлаар удирдан зохион байгуулах зорилгоор “Хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцах ерөнхий журам”-ыг 2023 оны 11 сарын 30-ны өдөр шинээр баталсан.</p>	IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)		Тийм	<p>Уг асуудал нь ХасБанкны Нийгэм байгаль орчны удирдлагын бодлогоор зохицуулагддаг. Хэрэв санхүүжилт хүссэн төсөл нь томоохон хэмжээний албадан нүүлгэлт үүсгэхээр байгаа эсэх, нутгийн иргэдийн хэвийн амьдрахад сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа эсэхээс шалтгаалан эрсдэлийг ангилж, санхүүжилт олгохоос татгалзах хүртэл арга хэмжээ авахыг уг бодлогод тусгасан.</p>	IFC Performance Standards
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?		Тийм	<p>2015 онд Ерөнхий захирлын Б-434 тоот тушаалаар ХасБанкны гомдол, талархлыг хүлээн авах, шийдвэрлэх журмыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>ХасБанк нь санал, гомдлыг салбар, тооцооны төв, харилцагчийн үйлчилгээний төвийн 18001888 тусгай дугаар, цахим хуудас болон социал сувгуудаар хүлээн авч, шийдвэрлэж байна.</p>	GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?		Тийм	<p>ХасБанкны Ерөнхий захирлын 2015 оны Б-434 дүгээр тушаалаар батлагдсан “Гомдол, талархлыг хүлээн авах, шийдвэрлэх журам”-ын дагуу ХасБанкны бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаа болон банкны ажилтантай холбоотой асуудлаар харилцагчийн гаргасан гомдол, талархлыг хүлээн авч, шийдвэрлэн, тайлагнах тогтолцоог хэрэгжүүлдэг. Харилцагчийн санал хүсэлт, гомдол, талархлыг дараах сувгуудаар хүлээн авч, шийдвэрлэдэг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Харилцагчийн үйлчилгээний төвийн 1800 1888 тусгай дугаар; - Салбар, тооцооны төвүүд; - Төв албаны reception, бичиг хэрэг; - www.xacbank.mn веб хуудас; - info@xacbank.mn цахим шуудан; мөн - Банкны социал сувгууд. 	IFC Performance Standards

S5.5	Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100	%	Ажиллагсад, олон нийтээс ирсэн санал, гомдлыг 100% шийдвэрлэж ажилласан.	GRI 413, SDG 8
S5.6	Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	0.2	%	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан шайбтай хоккейн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа. • Монголын Үндэсний Олимпын Хороо /МҮОХ/-ны 2023-2025 оны “АЛТАН ТҮНШ” байгууллагаар хамтран ажиллаж байна. • Хасын хүлэгүүд мэргэжлийн сагсан бөмбөгийн багтай 2004 оноос хойш 20 дахь жилдээ хамтран ажиллаж, ивээн тэтгэж байна. Энэ жил Хасын хүлэгүүд багийн 20 жилийн ойг тохиолдуулан “BANK SHOT” хэмээх хөтөлбөрийг зарлаад байна. Үндэсний дээд лигийн 2023-2024 оны улирлын туршид “Хасын Хүлэгүүд” багийн Bank Shot буюу самбардаж хийсэн бөмбөг бүрд 100,000 төгрөгийг тусгай дансанд хуримтлуулж сан үүсгэх бөгөөд нийт цугларсан мөнгөн дүнг ХасБанкны “Ирээдүйн саятан” хадгаламжтай хүүхдүүдэд сагсан бөмбөгийн спортоор хичээллэх сонирхлыг нь дэмжин, сонирхолтой өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулахад зориулна. • Жил бүр автомашингүй өдрөөр зохион байгуулдаг UB Marathon арга хэмжээг дэмжин хамтран ажиллалаа. • Шатрын спортын Их мастер Б.Мөнгөнтуулыг 6-р сарын 4-11-ний өдрүүдэд Казакстан улсын Алматы хотод болсон 18 дахь удаагийн Азийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд оролцоход дэмжин ажилласан бөгөөд Их мастер Б.Мөнгөнтуул хүрэл медаль авснаар Азийн аваргаас медаль хүртсэн Монголын хоёр дахь эмэгтэй шатарчин болж, Дэлхийн цомын тэмцээнд оролцох эрхээ авсан. • Хүүхдийн баярыг тохиолдуулан Шатрын их мастер Б.Мөнгөнтуултай хамтран шатрын спорт сонирхогч хүүхэд багачуудын дунд даалгавар биелүүлэх уралдаан зарлаж, 300 орчим хүүхэд идэвхтэй оролцсоноос 30 хүүхдийг шалгаруулан Б.Мөнгөнтуул их мастерын шатрын сургалтын эрхийн бичиг болон Ирээдүйн саятан хадгаламж, Хасхүүгийн гарын бэлгээр урамшуулсан. • ҮБ-ын “Залуу төлөөлөгч – Байгаль орчны манлайлал 2023” хөтөлбөрийг дэмжин, хамтран ажиллалаа. Уг хөтөлбөрийн хүрээнд байгаль орчин, технологи, хууль эрх зүйн салбарын 18-30 насны 30 залууг сонгон шалгаруулж, 2 сарын хугацаанд дэлхийн болон бүс нутгийн, мөн улс орны хэмжээнд тулгарч буй уур амьсгал, байгаль орчны асуудал, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээрх энэ салбарын мэргэжилтний сургалтад хамруулахаас гадна, баг болж бичил төсөл хэрэгжүүлэх боломжоор хангаж буй юм. • Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулан Монгол Улсын ууган сургуулийн нэг СЭЗИС-аас зохион байгуулсан “Мэргэжлийн ёс зүйн ач холбогдол” эсээ бичлэгийн уралдааныг дэмжин хамтран ажиллалаа. • ЮНЕСКО-ын биет бус соёлын өвд бүртгэгдсэн дэлхийн томоохон хөгжмийн наадмуудын нэг болох Итали улсын Сицил арал дахь Рагуса-Ибла хотод болох олон улсын мэргэжлийн хөгжимчид, зохиолчид, дуучдын уралдаанд МУСТА, төгөлдөр хуурч, төгөлдөр хуурын багш С.Алимааг шавь нарынх нь хамт оролцуулахад дэмжин ажиллалаа. • 00 буудалт даамын тамирчин Б.Есүйг Куракао улсад зохиогдох 100 буудалт даамын эмэгтэйчүүдийн насан хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон Америк Опен-2023 тэмцээнүүдэд оролцоход дэмжиж ажиллалаа. • Шольфийн холбооны “Presidents Cup” тэмцээнийг ивээн тэтгэж хамтран ажиллалаа. • Нээмсэглэл хамтлагийн 45 жилийн ойн концертыг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа. 	GRI 413, SDG 8

S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний мөнөжмөнт	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Тийм		2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Худалдан авалтын ерөнхий журамд нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн баталсан		GRI 204, SDG 8
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь		98%	%			GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь		3.5%	%	Төв алба болон салбар, тооцооны төвүүдэд нарны панель суурилуулсан. Архивын төмөр шүүгээг сэргээн дахин ашигласан. Бүрэн цахилгаан хөдөлгүүртэй автомашин худалдан авсан.		GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд									
G1.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?		Тийм		2023 оны 7 сарын 07-ны өдөр ТУЗ-өөс "Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам" болон "ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам"-ыг баталж, үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.		GRI 205, SDG 16
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь		27%	%	ХасБанкны ТУЗ нь нийт 4 хараат бус гишүүний орон тоотой ба үүнээс 3 гишүүн ажил үүргээ гүйцэтгэж байна. Нэг гишүүн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ба уг сул орон тоонд сонгон шалгаруулалтыг ТУЗ-ийн Засаглал, Нэр Дэвшүүлэх, Цалин Урамшууллын хороо (ЗНДЦУХ)-оос 2023 оны 6 дугаар сараас эхлэн зохион байгуулж, 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн ЗНДЦУХ-ны ээлжит хурлаар ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнд шинээр 3 нэр дэвшигчийг нэр дэвшүүлэхийг дэмжиж, Монголбанкнаас холбогдох зөвшөөрөл авахаар хүсэлт, материалаа хүргүүлсэн. Ийнхүү хуучин 3 гишүүний хамт нийт 6 нэр дэвшигчдийг 4 хараат бус гишүүний орон тоонд нэр дэвшүүлж буй нь хувьцаа эзэмшигчдэд сонголт өгөх зорилготой бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. Холбогдох зохицуулалтын дагуу, цаашид ХасБанкны ТУЗ 4 Хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй (33%)-гээр ажиллах юм.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?		Тийм		ТУЗ-өөс батлагдсан ХасБанкны Засаглалын кодексийн 1-р хэсгийн 1-д банк нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй байх зарчмуудыг баримтлах, мөн 3-р хэсгийн 2-т жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг "Жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалах зарчим нь хувьцаа эзэмшигчид адил тэгш хандах, санал хураалтад жижиг хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрхийг онцгойлон харгалзаж үзэх, Монголбанкны журмын дагуу ТУЗ-д хэд хэдэн хараат бус гишүүнийг томилж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдээллийг тухай бүр авах эрхээ саадгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг чухалчилна. Бүх хувьцаа эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай буюу хангалттай мэдээллээр хангана" гэж тусгасан.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16

G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?		Тийм	ХасБанкны ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-35 дугаар тогтоолоор Компанийн засаглалын кодексийг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. https://www.xacbank.mn/page/rules-regulations		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?		Тийм	2021 оны 12 сарын 28-ны өдөр ТУЗ-өөс ХасБанкны "Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого"-ыг баталсан. Тус бодлогын хүрээнд 2023 оны 7 сарын 7-ны өдөр ТУЗ-өөс "МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам" болон "Харилцагч таньж мэдэх ерөнхий журам"-ыг тус бүр баталж, өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлан, журмын хэрэгжилтийг Комплаенсийн хэлтэс хариуцан ажиллаж байна.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?		Тийм	Комплаенсийн хэлтсийн ажил үүргийн зохицуулалт, хяналт хийгдэх үндсэн чиглэлүүд болох харилцагч таньж мэдэхтэй холбоотой үйл ажиллагаа, гүйлгээний хяналт, хориг арга хэмжээ хяналт болон үйл ажиллагааны дагуу олж авсан баримт мэдээллийн хадгалалт, сургалт зэргийн талаар тусгасан "Комплаенсийн хөтөлбөр"-ийг 2022 оны 10 сарын 18-ны өдөр ТУЗ-өөр батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой үйл ажиллагаа нь "ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам"-ын дагуу зохицуулагдаж байна.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)									
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр		1550	хүн	2023 онд 1,550 иргэдийг хамруулан санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх өрийн дарамтад өртөхгүй байхтай холбоотой сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. Монголын Эмэгтэй Скаутын Холбоотой хамтарсан 15-25 насны 88 охидыг хамруулсан санхүүгийн болон бизнес эрхлэлтийн талаар мэдлэг олгох SHEOWNS арга хэмжээг Нийслэлийн иргэдийн танхимд зохион байгуулсан. НҮБ-ын залуу төлөөлөгч- Байгаль орчны манлайлал 2023-ыг дэмжин ажилласнаар 18-30 насны 30 залууг сонгон 2 сарын хугацаанд уур амьсгал, байгаль орчны асуудал, тэдгээрийг шийдвэрлэх, сургалтад хамруулахаас гадна баг болгон бичил төсөл хэрэгжүүлэх боломжоор хангасан.		SDG 1
FS2		БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь		100	%	Зээлийн судалгааны үе шатанд харилцагчийн бизнес үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, нутгийн уугуул иргэд болон тэдний амьдрах орчин, томоохон хэмжээний албадан нүүлгэлт мөн соёлын өвийн зүйлд учирч болох эрсдэл зэргийг нь үнэлэн эрсдэлийг 3 түвшинд ангилдаг бөгөөд өндөр эрсдэл учруулж болзошгүй тохиолдолд зээл олгохоос татгалздаг. Харилцагчийн 50 сая төгрөгөөс дээш дүнтэй, 12 сараас дээш хугацаатай бизнесийн бүх зээлд Нийгэм байгаль орчны эрсдэлийн үнэлгээ хийдэг бөгөөд уг үнэлгээ нь зээлийн эрсдэлийн дүгнэлтийн нэг хэсэг болж зээлийн санал шийдвэрлэх эрх бүхий этгээдийн шийдвэр гаргалтад нөлөөлж байна. Дээрх бүх процесс нь Банкны зээлийн үйл ажиллагааны холбогдох бүх журам, зохицуулалтад тусгагдсан бөгөөд зээл судлах, олгох, хянах, тайлагнах үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болсон.		Mongolian Sustainable Finance Principles

FS3	Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон (ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон) тогтвортой зээлийн эзлэх хувь		4.3	%	<p>2023 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар ногоон зээлийн таксономийн хүрээнд 118,563,024,844.84 ногоон зээлийн багц бүрдүүлснээр ногоон зээлийн багц 4.3%-д хүрч өмнөх онтой харьцуулахад 154% ийн өсөлттэй байна.</p> <p>Ногоон, тогтвортой бүтээгдэхүүн үйлчилгээ:</p> <ol style="list-style-type: none"> 1. ЭКО ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ https://www.xacbank.mn/product/136 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ https://www.xacbank.mn/product/1142 3. ХҮЛЭМЖИЙН ХИЙГ БУУРУУЛАХ БИЗНЕСИЙН ЗЭЭЛ https://www.xacbank.mn/product/102 		SDG 13, Mongolia Green Taxonomy
-----	-----------------------	--	--	-----	---	--	--	---------------------------------